

## **МОНГОЛЫН ГЕОПОЛИТИК, ДИПЛОМАТ АЖИЛЛАГААНЫ АСУУДЛЫГ ХӨНДСӨН НЭГЭН ШИНЭ БҮТЭЭЛИЙН ТУХАЙ**

*Ц.Баатар\**

Сүүлийн үед Монголын хөгжлийн гадаад хүчин зүйлийг глобал орчинтой нь нягт холбон авч үзэж, харьцуулан туурвисан шинэ бүтээл мэр сэр гарч, судалгааны эргэлтэнд орж, олны хүртээл болж байгаа нь нэн олзуурхууштай. Тийм нэгэн шинэ соргог, гадаад бодлогын шийдвэрийн онол арга зүйн үндэслэлийг дэвшүүлэн тавьж, энэ чиглэлийн судалгааны шанг анхлан татсан бүтээлийн тоонд манай нэртэй дипломатч, эрдэмтэн судлаач, профессор Гуудайн Төмөрчулууны туурвисан “Глобал ертөнц: Монголын геополитик, дипломат ажиллагаа” хэмээх чамбай бүтээл зүй ёсоор орно. Энэхүү бүтээл нь өмнөх үг, “Олон улсын харилцааны онолын асуудлууд”, “Монголын гадаад бодлогын өөрчлөлт, шинэчлэлт” гэсэн 2 томоохон хэсэг, төгсгөлийн оронд, хавсралт зэргээс бүрдсэн нийт 172 хуудас бүхий судалгааны нэгэн сэдэвт бүтээл юм. Бүтээлийн тэргүүн хэсэг Олон улсын харилцааны системч шинж чанар, түүний бүтэц, Бага улсууд тэдгээрийн онцлог, Гадаад бодлогын шийдвэрийн онол гэсэн 3 бүлгээс бүрдэнэ. Тэргүүн хэсэг бүхэлдээ олон улсын харилцааны онолын асуудлуудыг улируулан судалж, түүний хувьсал өөрчлөлтийг цогц байдлаар хөндөн авч үзсэн байна.

Зохиогч улс төрийн амьдрал бол үйл ажиллагааны систем гэж үзээд олон улсын харилцааны онолын асуудлыг хөндөхдөө энэ зарчмыг баримталсан байна. Онолын хувьд системийн тогтвортой байх эсэх нь шийдвэр гаргагчдын авсан мэдээллийн мөн чанараас шалтгаална. Системийг хэвээр хадгалахын тулд өөрчлөгдөн буй орчинтойгоо дасан зохицох, эс бөгөөс түүнийг өөрчлөх, боловсронгуй болгох үйл явц болохыг олон улсын харилцааны онол, үзэл баримтлалын хүрээнд тал бүрээс нь нэн харуулаад олон улсын бодлого, улс төрийн үйл явцад бүтцийн элементүүд, субъектуудын гүйцэтгэх үүрэг, ролийг тодорхойлох оролдлого хийж, өөрийн санаа оноог дэвшүүлжээ.

Профессор Г.Төмөрчулуун Олон улсын харилцаа нь эцсийн дүндээ үндэсний, үндэстэн хоорондын, бүс нутгийн болон глобал эрх ашиг, асуудлуудаас бүрэлддэг. Глобал эрх ашиг, асуудлууд нь олон улсын харилцааг зохицуулах, харьцуулах, өрсөлдүүлэх үндсэн хэрэгсэл төдийгүй олон улсын харилцааг тодорхойлогч үндэс суурь болж, хувьсан өөрчлөгдөж байдаг зүй тогтолг үйл явц хэмээн тодорхойлсон байна.

Доктор Г.Төмөрчулуун Олон улсын харилцаанд үндэсний имиж чухал болохыг тэмдэглээд монголчууд бидний гарал үүслийг тэмдэглэж үлдээсэн “Монголын нууц товчоо” нь монголчууд бидний амин шүтээн,

\* Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

монгол үндэстний имиж тул түүнийг үеэс үед өвлүүлэн үлдээхийн тулд сургалтын хөтөлбөрт оруулах нь үндэсний имиж бэхжихэд нэн тустай гэсэн санаа дэвшүүлснийг бодлого боловсруулах болон шийдвэр гаргах түвшинд ажиллагсад анхааран үзээсэй билээ.

Түүнчлэн зохиогч алив улсын гадаад бодлогод прагматик онолын үндэслэл болох “алив үнэт зүйлсийг бус, харин гарах үр өгөөж, олох ашгийг үндэс болгох” буюу ардын маань хэлдгээр авах, гээхийн ухаанаар хандах чиг хандлага дэлхийн улс орнуудад түгэн дэлгэрч байгааг Хятад, ОХУ, Монгол Улсын жишээн дээр авч үзсэн байна. /17 дахь тал/

Өнгөрсөн зууны 90-ээд оноос глобалчлалтай холбогдон олон улсын харилцаанд гарч ирсэн онолын шинэ урсгал болох “Хязгаарлагдмал бүрэн эрхт байдлын” тухай номлолын талаар зохиогч нэлээд үл үндэстэй тайлбарласан нь танин мэдэхүйн ач холбогдолтой юм. Түүнчлэн олон улсын харилцаанд бага улсууд гэдэг ойлголт хэрхэн бий болсон, түүний онол арга зүйн үндэслэл юу болох, бага улсын гадаад бодлого, дипломат ажиллагаа, олон улсын тавцанд гүйцэтгэх үүрэг ролийн асуудлыг гадаад бодлогын онол, үзэл баримтлалын үүднээс нягтлан авч үзээд гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явц зохион байгуулалтын, оюуны гэсэн 2 тулгууртай бөгөөд тэр нь танин мэдэхүйд тулгуурлана. Танин мэдэхүй нь мэдээлэлд, мэдээлэл нь дүн шинжилгээнд тугуурлах бөгөөд дүн шинжилгээнээс шийдвэрт хүрдэг болохыг тал бүрээс нь нээн харуулсан байна.

Монголын гадаад бодлогын өөрчлөлт, шинэчлэлт гэсэн хоёрдугаар хэсэг Монголын гадаад бодлогын чиглэл, эрх зүйн үндэс өөрчлөгдөн шинэчлэгдсэн нь, Гадаад бодлогын практик асуудлууд, Олон улсын аюулгүй байдал ба Монголын гадаад бодлого гэсэн гурван бүлгээс бүрдэл болно. Зохиогч хоёрдугаар хэсгээ бүхэлд нь өнгөрсөн зууны 90-ээд оноос хойшхи Монгол Улсын гадаад бодлогын өөрчлөлт шинэчлэлтэд зориулжээ. Монголын гадаад харилцааны бодлогод гарсан зарчмын өөрчлөлтүүдийн үндсэн шалтгаан нь дотоод улс төр, нийгэм-эдийн засгийн тогтолцооны өөрчлөлттэй шууд холбоотой болохыг тэмдэглээд Монголын гадаад бодлогын орчныг хөрш орнуудын, бүс нутгийн, глобал гэсэн гурван түвшинд нэлээд дэлгэрэнгүй авч үзжээ.

90-ээд оноос хойшхи Монгол Улсын гадаад харилцааны чиглэл, зорилго, зарчим, шийдвэр гаргах механизм, эрх зүйн хувьд шинэчлэгдэж, гадаад бодлогын үзэл баримтлалаа тунхагласан ардчилсан чиг баримжаатай улс болсон үйл явцыг тал бүрээс нь нягтлан харуулж судалгааны үндэслэлтэй үнэлэлт дүгнэлт өгсөн байна.

Эрдэмтэн дипломатч Гуудайн Төмөрчулууны туурвисан энэхүү бүтээл улс төрчид, бодлого боловсруулагчид болон гадаад харилцааны чиглэлийн практик ажилтан, эрдэмтэн судлаачид, их дээд сургуулийн багш, оюутнуудын анхаарал сонирхолыг зүй ёсоор татна гэдэгт найдна.